



ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/288

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Харьяатын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан "Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал"-ын 3.2, 10.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2014 оны А/226 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалт"-ын 1.1.11.2 дахь хэсгийн "хувиараа хөдөлмөр эрхлэгч бол түүний орлогынх нь талаарх банк, татварын байгууллагын тодорхойлолт" гэснийг хассугай.

2. Энэ тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Иргэний харьяаллын газар /А.Энх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БОЛД